



БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ 2020/2



АГУУЛГА

		Хуудасны дугаар
	ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2016-2020 ОН	3
	БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮД	4
	НИЙГМИЙН ДААТГАЛ	6
	НИЙГМИЙН ХАЛАМЖ	7
	ЭРҮҮЛ МЭНД	9
	ГЭМТ ХЭРЭГ	10
	ҮНЭ ХАНШ	12
	АЖ ҮЙЛДВЭР	16
	НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	18

ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүснэгт 1. Малын тоо, 2019 оны жилийн эцэст, малын төрөл, хороогоор

Үзүүлэлт	Дүүргийн дүн	Үүнээс: хороогоор				
		I	II	III	IV	V
Нийт мал	200 183	50 725	13 821	46 229	53 339	36 069
Үүнээс:						
Тэмээ	210	48	-	160	2	-
Адуу	16 066	4 247	902	3 928	3 718	3 271
Үхэр	16 823	4 501	1 504	3 793	4 074	2 951
Хонь	99 691	25 368	6 864	23 491	27 723	16 245
Ямаа	67 393	16 561	4 551	14 857	17 822	13 602

Хүснэгт 2. Хүн ам зүйн үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 I-II	2017 I-II	2018 I-II	2019 I-II	2020 I-II
Суурин хүн ам	тоо	28 973	28 787	29 512	29 663	
Төрөлт	тоо	131	73	104	100	102
Нас баралт	тоо	28	23	20	30	26
Шилжиж ирсэн	тоо	188	168	109	47	611 ²
Цэвэр өсөлт	хувь	0.36	0.17	0.28	0.24	2.26 ¹

¹ - өмнөх оны суурин хүн амаас тооцов.

² - Улаанбаатар хотод байнга оршин суухаар ирэх иргэдийн шилжилт хөдөлгөөнийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл түр хязгаарласан Нийслэлийн Засаг даргын захирамжийн хугацаа дууссантай холбоотой шилжилт хөдөлгөөний бүртгэл нэмэгдсэн.

Зураг 1. Нутаг дэвсгэрийн хэмжээ



БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны захиргааны статистик мэдээгээр 2020 оны 2 сарын эцэст 448 иргэн ажил хайж бүртгүүлсэн байна. Үүнээс 9 (2.0%) иргэн нь одоо хөдөлмөр эрхэлж байгаа ба 63 (14.1%) иргэн нь ажлаас чөлөөлөгдсөн байна. Дүүргийн хөдөлмөрийн албанд бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэд 336 болж өнгөрсөн оноос 89 (36.0%) хүнээр өссөн байна. Тайлант хугацаанд ажил хайж буй иргэдийн 7 (1.6%) нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлж байна.

Зураг 2. Ажил хайгч иргэдийн хөдөлгөөн




Тайлант сард ажил идэвхтэй хайж байсан 103 иргэн шинээр бүртгүүлсэн бөгөөд үүнээс 51 (49.5%) нь эмэгтэйчүүд байна.

Зураг 3. Ажил хайгч иргэд, шалтгаанаар



Мөн энэ хугацаанд 31 иргэн ажилд зуучлуулан орсон ба хувьцаат компанид 2, хязгаарлагдмал хариуцлагатай компанид 17, төсөвт байгууллагад тус бүр 7, орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт 4 иргэн, бусад хэлбэрийн байгууллагад 1 иргэн тус тус ажилд орсон байна.

Зураг 4. Ажил хайгч иргэд, насны бүлгээр



Тайлант сард ажил хайж байгаа иргэдийн 136 (30.4%) нь 15-24 насны, 147 (32.8%) нь 25-34 насны залуучууд, 93 (20.8%) нь 35-44 насныхан, 66 (14.7%) нь 45-60 насны, 6 буюу (1.3%) нь 60-аас дээш насны иргэд байна.

Хүснэгт 3. Ажил хайгч иргэд, боловсролоор, II сард

Үзүүлэлт	Ажилгүйчүүдийн тоо		Үүнээс: эмэгтэй	
	2019 II	2020 II	2019 II	2020 II
Ажилгүйчүүд, бүгд	269	448	141	244
Үүнээс:				
Дээд боловсролтой	84	78	59	54
Тусгай дунд боловсролтой	12	21	5	11
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	41	50	11	21
Ерөнхий боловсролтой	128	286	64	155
Бага болон боловсролгүй	4	13	2	3

Ажил хайж буй иргэдийн 78 (17.4%) нь дээд боловсролтой, 12 (4.7%) нь тусгай дунд боловсролтой, 50 (11.2%) нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 286 (63.8%) нь ерөнхий боловсролтой, 13 (2.9%) нь бага боловсролтой болон боловсролгүй ажээ. Ажил хайгч иргэдийн 244 (54.5%) нь эмэгтэйчүүд байна.




НИЙГМИЙН ДААТГАЛ

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангийн орлого 4.2 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 455.2 (12.3%) сая төгрөгөөр, зарлага 4.3 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 555.7 (15.0%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Нийт орлогын 2.6 (61.7%) тэрбум төгрөг тэтгэврийн сангаас, 329.8 (7.9%) сая төгрөг тэтгэмжийн сангаас, 429.9 (10.3%) сая төгрөг ҮОМШӨ сангаас, 766.2 (18.4%) сая төгрөг эрүүл мэндийн даатгалын сангаас, 70.2 (1.7%) сая төгрөг ажилгүйдлийн сангаас тус тус төвлөрсөн байна.


Зураг 5. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сараар



Хүснэгт 4. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага

Үзүүлэлт	2019		2020		$\frac{2020.II\%}{2019.II}$	$\frac{2020.I - II\%}{2019.I - II}$
	II	I-II	II	I-II		
	сая төгрөг					
Сангийн орлого, бүгд	2 024.4	3 708.4	2 001.9	4 163.6	98.9	112.3
тэтгэврийн сан	1 250.0	2 290.0	1 234.1	1 627.4	98.7	112.1
тэтгэмжийн сан	161.0	294.0	158.8	206.3	98.6	112.2
ажилгүйдлийн сан	34.4	62.4	34.0	44.4	98.8	112.5
ҮОМШӨ ¹ -ний сан	210.0	383.0	207.2	269.7	98.7	112.2
ЭМД ² -ын сан	369.0	679.0	367.8	461.7	99.7	112.8
Сангийн зарлага, бүгд	1 848.9	3 704.7	2 247.9	4 260.4	121.6	115.0
тэтгэврийн сан	1 675.0	3 239.0	1 978.5	3 740.9	118.1	115.5
тэтгэмжийн сан	23.4	127.4	105.0	177.8	448.7	139.6
ҮОМШӨ-ний сан	129.8	283.0	131.6	276.0	101.4	97.5
ЭМД-ын сан	-	-	-	-	-	-
Ажилгүйдлийн сан	20.7	55.3	32.8	65.7	158.5	118.8

Зураг 6. Нийгмийн даатгалын сангийн зарлагын бүтэц



Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангаас 4380 хүнд 3.7 тэрбум төгрөгийн тэтгэвэр, 443 хүнд 177.8 сая төгрөгийн тэтгэмж, 217 хүнд 276 сая төгрөгийн үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэмж, 32 хүнд 65.7 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж тус тус олгосон байна.



НИЙГМИЙН ХАЛАМЖ

2020 оны 2 сарын байдлаар нийгмийн халамжийн сангийн орлого 877.9 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 140.4 (13.8%) сая төгрөгөөр буурсан байна. Нийгмийн халамжийн сангийн нийт орлогын 869.2 (99.0%) сая төгрөг улсын төсвөөс, 6.0 (0.7%) сая төгрөг орон нутгийн төсвөөс 2.8 (0.3%) сая төгрөг бусад орлогоор тус тус санхүүжигдсэн байна.


¹ Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

² Эрүүл мэндийн даатгал

Тайлант хугацаанд нийгмийн халамжийн сангаас 454 хүнд 160.7 сая төгрөгийн тэтгэвэр, 338 хүнд 58.6 сая төгрөгийн тэтгэмж, 262 жирэмсэн эхчүүдэд 8.3 сая төгрөгийн тэтгэмж, “Алдарт эх”-ийн одонтой 1789 эхчүүдэд 236.6 сая төгрөг, 1183 эх “Цалинтай ээж” хөтөлбөрт хамрагдаж 58.0 сая төгрөг, 1332 ахмадуудад 111.7 сая төгрөгийн насны хишиг олгосон байна.

Ахмад дайчин, гавьяат цолтой 15 хүнд 4.6 сая төгрөг, 824 ахмад настанд 38.5 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлж, 4773 хүнийг хүнс тэжээлийн хөтөлбөрт хамруулж 73.5 сая төгрөг, 91 хүнд амжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 31.7 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 65 иргэдэд 4.4 сая төгрөгийн хөнгөлөлт тус тус олгосон байна.

Зураг 7. Нийгмийн халамжийн сангийн зарлагын бүтэц



Хүснэгт 5. Нийгмийн халамжийн сангийн орлого, зардал

Үзүүлэлт	2019		2020		2020. II% 2019. II	2020. I – II% 2019. I – II
	II	I-II	II	I-II		
	Сая төгрөг					
Сангийн орлого	363.8	1 018.3	609.4	877.9	167.5	86.2
Улсын төсвөөс	363.4	1 017.4	601.4	869.1	165.5	85.4
Орон нутгийн төсвөөс	-	-	6.0	6.0	-	-
Бусад орлого	0.4	0.9	2.0	2.8	5.0*	3.1*
Сангийн зарлага	284.2	820.5	601.4	788.2	2.1*	96.1
Тэтгэвэр	77.1	140.7	84.4	160.7	109.5	114.2
Тэтгэмж	23.0	42.5	30.9	58.6	134.3	137.9
Амжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж	11.7	25.0	18.0	31.7	153.8	126.8
"Алдарт эх" I одонт эхчүүд	7.8	125.9	115.4	115.4	14.8*	91.7
"Алдарт эх" II одонт эхчүүд	20.5	134.0	121.2	121.2	6.0*	90.4
Жирэмсэн эхчүүдийн тэтгэмж	7.4	14.8	0.4	8.3	5.4	56.1
Насны хишиг	7.5	110.2	111.7	111.7	14.9*	101.4
Ахмад дайчин, гавьяатын нэмэгдэл	9.6	12.2	2.3	4.6	24.0	37.7
Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт	16.7	18.8	36.7	38.5	2.2*	204.8
ХБИ-д үзүүлсэн хөнгөлөлт	6.8	9.1	3.2	4.4	47.1	48.4
“Хүнс тэжээл” халамжийн хөтөлбөр	32.2	69.6	73.5	73.5	2.3*	105.6
Цалинтай ээж	63.4	117.2	2.1	58.0	3.3	49.5
Өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмж	-	-	-	-	-	-
ОНО-д түшиглэсэн халамж	-	-	1.2	1.2	-	-
Бусад үйлчилгээ	0.5	0.5	0.4	0.4	80.0	80.0


*-дахин өссөн



ЭРҮҮЛ МЭНД

Дүүргийн хэмжээнд 2020 оны эхний 2 сард 116 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 16 (16.0%) хүүхдээр өссөн байна. Энэ хугацаанд 48751 хүн үзлэгт хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 18453 (61.0%) хүнээр, хэвтэн эмчлүүлсэн 1509 хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 83 (5.8%) хүнээр тус тус өссөн байна.


Зураг 8. Амбулаторийн үзлэг 2020 оны II сар



Хүснэгт 6. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл эхний 2 сард

Үзүүлэлт	2019 I-II	2020 I-II	$\frac{2020.I - II\%}{2019.I - II}$
Амаржсан эхийн тоо	100	116	116.0
Үүнээс бусад аймгийн харьяат	24	37	154.2
Амьд төрсөн хүүхэд	99	115	116.2
Үүнээс бусад аймгийн харьяат	24	37	154.2
Эхийн эндэгдэл	-	1	-
Нэг хүртэлх насандаа эндсэн хүүхэд	1	1	100.0

Зураг 9. Халдварт өвчин, сараар



2020 оны эхний 2 сард халдварт паразит өвчний 33 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 49.3%-ийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 8 (32.0%) тохиолдлоор, цочмог халдварт өвчний 34 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 32.0%-ийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 18 (112.5%) тохиолдлоор тус тус өссөн байна. Дүүргийн дунджаар 10000 хүн тутамд ногдох халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо 22.6 байгаа нь өмнөх оны мөн үеэс 8.6 продицимиллээр өссөн байна.

Хүснэгт 7. Бүртгэгдсэн халдварт өвчин

Үзүүлэлт	2019 I-II	2020 I-II	Өсөлт бууралт
Халдварт, паразит өвчин	25	33	8
Заг хүйтэн	9	25	16
Тэмбүү	8	4	-4
Мөөгөнцөр /кандидоз/	3	-	-3
Трихомониаз	3	4	1
Кандилом	1	-	-1
хомхой	1	-	-1
Цочмог халдварт өвчин	16	34	18
Цусан суулга	-	7	7
Гепатит А	1	1	-
Скарлатин	-	1	1
Салхин цэцэг	10	18	8
Сальмонеллез	-	4	4
Гар хөл амны өвчин	-	1	1
Сүрьеэ	5	2	-3
Нийт халдварт өвчин	41	67	26



ГЭМТ ХЭРЭГ

2020 оны эхний 2 сард дүүргийн хэмжээнд 31 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 8 (20.5%) хэргээр буурсан байна. Гэмт хэргийн илрүүлэлт 31.0 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.3 пунктээр доогуур үзүүлэлт юм.

Хүснэгт 8. Бүртгэгдсэн гэмт хэрэг

Хэргийн төрөл	2019 I-II	2020 I-II	Хэргийн өсөлт		Дүнд эзлэх хувь
			тоо	хувь	
Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд	39	31	-8	-20.5	100.0
Хүний амь нас хохироосон	1	-	-1	-100.0	0.0
Хүний амь нас хохирсон	3	1	-2	-66.7	3.2
Болгоомжгүйгээр хүний амь нас хохироосон	1	-	-1	-100.0	0.0
Хүний эрүүл мэндэд хохирол учруулах	11	8	-3	-27.3	25.8
Бусдын эд хөрөнгө хулгайлах	7	9	2	28.6	29.0
Бэлгийн халдашгүй байдал	3	1	-2	-66.7	3.2
Эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх	1	-	-1	-100.0	0.0

Залилан мэхлэх	8	8	0	0.0	25.8
Хуурамч мөнгөн тэмдэгтээр гүйлгээ хийх	1	-	-1	-100.0	0.0
Гээгдэл эд зүйл завших алдаатай гүйлгээ хийх	-	1	1	-	3.2
Хөрөнгө завших	-	1	1	-	3.2
Бусдын эд хөрөнгө устгах, гэмтээх үрэгдүүлэх	-	1	1	-	3.2
Мал хулгайлах	-	1	1	-	3.2
Тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих	2	-	-2	-100.0	0.0
Цахим мэдээлэлд хууль бусаар халдах	1	-	-1	-100.0	0.0
Хэрэг илрүүлэлтийн хувь	35.3	31.0			


Зураг 10. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар




Бүртгэгдсэн гэмт хэргийн дийлэнх буюу 8 (25.8%) нь хүний эрүүл мэндэд хохирол учруулах хэрэг, 9 (28.6%) нь бусдын эд хөрөнгө хулгайлах хэрэгүүд байна.

Тайлант хугацаанд бусдын эд хөрөнгө хулгайлах гэмт хэрэг 9, хүний эрүүл мэндэд хохирол учруулах, залилан мэхлэх гэмт хэрэг тус бүр 8, хүний амь нас хохирсон, бэлгийн халдашгүй байдал, гээгдэл эд зүйл завших алдаатай гүйлгээ хийх, хөрөнгө завших, бусдын эд хөрөнгө устгах, гэмтээх үрэгдүүлэх, мал хулгайлах гэмт хэргүүд тус бүр 1 бүртгэгдсэн байна.

Зураг 11. Согтуугаар болон гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг, сараар



Зураг 12. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, жил бүрийн эхний II сард




Хүснэгт 9. Гудамж талбайд болон согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг

Хэргийн төрөл	2019 I-II		2020 I-II	
	Согтуугаар	Гудамж талбайд	Согтуугаар	Гудамж талбайд
Бүгд	8	8	5	4
Хүний амь нас хохироосон	-	1	-	-
Хүний амь нас хохирсон	-	1	-	-
Бэлгийн халдашгүй байдал	8	4	5	-
Бусдын эд хөрөнгө хулгайлах	-	2	-	4
Дүнд эзлэх хувь	20.5	20.5	16.1	12.9

Тайлант хугацаанд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг болон 5 болж өмнөх оны мөн үеэс 3 (37.5%) хэргээр, гудамж талбайд 4 хэрэг үйлдэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 4 (50.0%) хэргээр тус тус буурсан байна. Мөн согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг нийт гэмт хэргийн 16.1 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.4 пунктээр, гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг нийт хэргийн 12.9 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 7.6 пунктээр тус тус буурсан байна.

Зураг 13. Гудамж талбайд болон согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн эзлэх хувь, жил бүрийн II сар





ҮНЭ ХАНШ

2020 оны 2 сарын хүнсний өргөн хэрэглээний 21 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг ажиглахад доорх байдалтай байна.

Хүснэгт 10. Хүнсний барааны үнийн ажиглалт, 2020 оны 2 сарын дундаж үнэ


Хүнсний бараа		Хэмжээ нэгж	Хишиг-Уул супер маркет	Марал хүнсний дэлгүүр	Хэрлэн хүнсний зах	Миний нутаг супер маркет
"Алтан тариа" гурил	Дээд	кг	1 499	1 500		1 500
	I зэрэг	кг	1 299	1 200		1 200
	II зэрэг	кг	900	950		900
Будаа	цагаан	кг	2 649	2 400		2 400
	шар	кг	3 500	3 525		3 550
Хонины мах	ястай	кг			8 063	
	цул	кг			9 563	
Үхрийн мах	ястай	кг			10 563	
	цул	кг			12 938	
Адууны мах, ястай		кг			8 363	
Ямааны мах		кг			7 063	
Элсэн чихэр		кг	2 200	2 200		2 100
Сүү /задгай/		л	2 100			
Тараг /задгай/		л	2 600			
Цөцгийн тос, Орос		кг	4 000	4 000		4 000
Байцаа		кг			1 800	
Манжин		кг			3 000	
Төмс	монгол	кг			900	
Лууван	монгол	кг			1 500	
Сонгино	хятад	кг			2 500	
	монгол	кг			3 500	
Сармис, булцуу		ш			300	
Огурцы, хятад		кг			6 500	
Помидор, хятад /үрлэн/		кг			6 500	
Ургамлын тос/ sunny gold/		ш	4 400	4 400		4 500
Өндөг		ш	400	380		350
Талх	Есөн шанд	том 900 гр	ш	1 800	1 800	1 800
		Дунд 700 гр	ш	1 700	1 700	1 700
		жижиг 500 гр	ш	1 100	1 100	1 100
	Атар талх		ш	1 150	1 200	1 200

Хүснэгт 11. Үйлчилгээний үнийн тариф, (НӨТ-гүй үнэ)

Үзүүлэлт	Хэмжин нэгж	Айл өрхөд (төгрөг)	Хэмжин нэгж	Аж ахуйн нэгж байгууллагад (төгрөг)
Дулаан	1м ²	660	1м ³	1632
Дулааны суурь тариф	40 м ² хүртэл	3 000	-	-
	40м ² - 80м ²	5 000		
	81м ² -аас дээш	10 000		
	1 хүн (тоолуургүй)	3 162		
Халуун ус	Өвөл 1м ³ (тоолууртай)	1 632	1 гкал	76 611
	Зун 1 хүн (тоолуургүй)	4 428		
	1м ³ (тоолууртай)	1 632		
	1 хүн (тоолуургүй)	1.2		
Цэвэр ус*	1 л (тоолууртай)	1.0	1 л (тоолууртай)	1.20
	суурь хураамж	1 800	1 л (зөөврөөр)	5.45
	1 хүн (тоолуургүй)	1.2	1 л (тоолуургүй)	1.8
	1 л (тоолууртай)	1.0	1 л (тоолууртай)	1.4
Бохир ус*	суурь хураамж	15.0	1 л (зөөврөөр)	1000

* 2019 оны 9 сарын 15-нээс мөрдөж байгаа тариф, 2020 оны 01 дүгээр сарын 20-ноос мөрдөж буй цэвэр, бохир усны тариф

Зураг 14. “Алтан тариа” гурилын дундаж үнэ, жил бүрийн 2-р сард



Зураг 15. Нэг кг махны дундаж үнэ, жилийн бүрийн 2-р сард



Хүснэгт 12. Цахилгааны үнийн тариф, (НӨТ-гүй үнэ)

Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
* Айл өрхөд борлуулах цахилгааны тариф		
Энгийн тоолууртай		
Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц	төг/квт.ц	102.9
Сарын нийт хэрэглээний 151 кВт.ц-аас дээш	төг/квт.ц	122.7
2 тарифт тоолууртай		
Өдрийн хэрэглээ /06.00-21.00/	төг/квт.ц	108.8
Орой, шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	81.6
Сарын суурь тариф	төг/сар	2 000.0
* Аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгааны тариф		
Энгийн тоолууртай /бусад үйлдвэр аж ахуйн нэгж байгууллага/		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	133.0
Оройн хэрэглээ /17.00-24.00/	төг/квт.ц	214.3
Шөнийн хэрэглээ /24.00-06.00/	төг/квт.ц	81.6
3 тарифт тоолууртай /уул уурхай, боловсруулах аж үйлдвэр/		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	155.9
Оройн хэрэглээ /17.00-24.00/	төг/квт.ц	276.0
Шөнийн хэрэглээ /24.00-06.00/	төг/квт.ц	77.1

* 2019 оны 5 сарын 1-ны өдрөөс мөрдөж буй тариф

Хүснэгт 13. Малын гаралтай бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ


	2018 II	2019 II	2020 II
	төгрөг		
Адууны шир	25 000	8 000	8 500
Үхрийн шир /2.3 метрээс доош/	20 000	7 500	4 500
Үхрийн шир /2.3 метрээс дээш/	38 000	15 000	6 000
Хонины арьс	5 000	2 000	1 500
Ямааны арьс	28 000	30 000	28 000

Хүснэгт 14. Түлш шатахууны үнэ

Шатахууны нэр төрөл	2016 II	2017 II	2018 II	2019 II	2020 II	Өөрчлөлт	
						төгрөг	хувь
АИ -76,80	1 440	1 440	1 508	1 738	1 810	72	4.1
АИ -92,93	1 540	1 540	1 654	1 813	1 860	47	2.6
Дизель түлш	1 650	1 650	1 781	2 328	2 490	162	7.0

2020 оны 2 сарын байдлаар түлш, шатахууны үнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад АИ-92 бензин 47 төгрөгөөр (2.6), АИ-80 бензин 72 төгрөгөөр (4.1), дизель түлш 162 төгрөгөөр (7.0) тус тус өссөн байна.

Зураг 16. Хот хоорондын зорчигч тээврийн үнэ, (чиглэл: УБ-БН, БН-УБ)




АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлт 2020 оны эхний 2 сард 31.0 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 567.9 (1.8%) сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 15. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт


Үзүүлэлт	Хэмжих нэгж	Биет хэмжээ			Үнийн дүн, сая төгрөг		
		2019 I-II	2020 I-II	$\frac{2020}{2019} \%$	2019 I-II	2020 I-II	$\frac{2020}{2019} \%$
Нүүрс олборлолт	м.тн	950.0	870.9	-79.1	29 925.0	29 175.2	-749.8
Дулаан дамжуулалт	м.гкал	48.0	49.3	1.3	1 559.3	1 729.1	169.8
Талх үйлдвэрлэлт	тн	22.2	37.0	14.8	30.9	51.9	21.0
Нарийн боов үйлдвэрлэлт	тн	17.1	9.3	-7.8	76.0	67.1	-8.9
Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт		1 037.3	966.5	-70.8	31 591.2	31 023.3	-567.9

Зураг 17. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, сая төгрөг, сараар




Оны эхний 1 сарын байдлаар нүүрс олборлолт биет хэмжээгээр 79.1 (8.3%) мянган тонн, үнийн дүнгээр 749.8 (2.5%) сая төгрөгөөр буурсан байгаа нь түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон Засгийн газрын 2018 оны 62 тогтоолтой холбоотойгоор эрэлт буурсан. Харин дулаан үйлдвэрлэлт биет хэмжээгээр 1.3 (2.7%) мянган гкал-аар өссөн ч үнийн дүнгээрээ 169.8 (10.9%) тонноор өссөн байгаа нь дулааны үнийг өнгөрсөн онд нэмсэнтэй холбоотой байна. Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлтээс талхны үйлдвэрлэлт 14.8 (66.7%) тонноор өсч, нарийн боовны үйлдвэрлэлт 7.8 (45.6) тонноор буурсан байна.

Зураг 18. Талх, нарийн боов үйлдвэрлэлт, сараар, сая төгрөг



Зураг 19. Нүүрс олборлолт, мянган тонн, жил бүрийн II сард



Тайлант сарын байдлаар 1 кг талхны үнэ 1402.7 төгрөг , 1 кг нарийн боовны үнэ 7215.1 төгрөг байна.




НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Тайлант хугацаанд нийтийн аж ахуй үйлчилгээний салбарын орлого 388.4 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 87.9 (29.3%) сая төгрөгөөр өссөн байна. Нийт орлогын 188.6 (48.6%) сая төгрөгийг хүн амаас оруулсан орлого эзэлж байна.

Хүснэгт 16. Орон сууц нийтийн аж ахуйн орлого

Үзүүлэлт	2019 I-II	2020 I-II	Өсөлт бууралт
	сая төгрөг		
Нийт орлого	300.5	388.4	87.9
Орон сууц	33.5	103.7	70.2
Ус борлуулалт, бүгд	133.9	141.4	7.5
Хүн амд	72.3	76.2	3.9
Аж ахуйн нэгжид	61.6	65.2	3.6
Сувагжуулалт	117.3	122.4	5.1
Бусад	15.7	20.9	5.2

Зураг 20. Нийтийн үйлчилгээний салбарын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, сая төгрөг



Хүснэгт 17. Сууц өмчлөгчдийн холбоодын орлогын биелэлт


Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ%
	мянган төгрөг		
Нийт дүн	90 675.0	66 484.0	73.3
Тавлаг өргөө	16 501.0	12 622.7	76.5
Маргад өргөө	17 587.8	12 391.6	70.5
Сод хөгжил	21 639.2	17 758.9	82.1
Шинэ элч	17 251.4	12 116.7	70.2
Уурхайчин	8 320.0	6 073.6	73.0
Содон суварга	9 375.6	5 520.5	58.9

СОНИРХОЛТОЙ СТАТИСТИК

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН


Багануур дүүрэгт 2019 оны жилийн эцсийн байдлаар 1063 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаа нь өнгөрсөн оноос 24 (2.3%) хүнээр өссөн байна.

Зураг 1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 350 (32.9%) нь төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй байгаа ба 713 (67.1%) нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна.


Зураг 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, шалтгаанаар



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг насны бүлгээр ангилан харахад 35-64 насны бүлэг 687 (66.1%) иргэн байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд 0-4 насны бүлэг 22 (2.1%) хүүхэд байгаа нь хамгийн бага үзүүлэлт байна.


35-64 насны бүлгийн хүмүүсийн 155 (22.6%) нь төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй байгаа бол 532 (77.4%) нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна. Үүний 362 (68.1%) нь ердийн өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

Зураг 3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд насны бүлгээр




Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 451 (42.4%) нь эмэгтэйчүүд байна.

Зураг 4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд хүйсээр



Зураг 5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд төрлөөр



ИРГЭДЭД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ



ГАРАА САЙТАР
САВАНДАЖ УГААХ



ОЛОН ХҮН ЦУГЛАРСАН
ГАЗРААР ЯВАХГҮЙ БАЙХ



ГАДУУР ЯВАХДАА
БЭЭЛИЙ ӨМСӨХ



БОХИР ГАРАА АМ, ХАМАР,
НҮДЭНДЭЭ ХҮРГЭХГҮЙ,
НУХАХГҮЙ БАЙХ



ХАНИАЖ, НАЙТААЖ
БАЙГАА ХҮНЭЭС ХОЛ БАЙХ



БУХИМДАХГҮЙ
ТАЙВАН БАЙХ



ХАЛУУН, БҮЛЭЭН
ШИНГЭН ИХЭЭР УУХ



АМНЫ ХААЛТ
ХЭРЭГЛЭХ



ӨГЛӨӨ, ОРОЙД СОД,
ДАВС, САРМИС,
ЦАРВАНГИЙН
УУСМАЛЫН АЛЬ НЭГЭЭР
ХООЛОЙГ ЗАЙЛАХ



БУСАДТАЙ ГАР
БАРИХ, ҮНСЭХЭЭС
ЗАЙЛСХИЙХ



ТҮҮХИЙ УС УУХГҮЙ
БАЙХ



НУС, ЦЭР, ШҮЛСЭЭ
ИЛ ЗАДГАЙ
ХАЯХГҮЙ БАЙХ



WWW.1212.MN СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Статистик 

Мэдээ, мэдээлэл 

Номын сан 

Мэдлэгээ шалгах
ТОГЛОМ 

Валютын ханш 





аппликейшнаас

СТАТИСТИКИЙН мэдээллээ аваарай

Data lab | тооллого судалгааны
микро мэдээллийн сан

Social network

 www.facebook.com/StatisticMongolia/

 www.twitter.com/statistic_mn

Лавлах утас

 **1900-1212**

Цахим шуудан

 information@nso.mn